

ЭНЭРЭНГҮЙ ЁСНЫ ЗАРЧМЫГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ БОЛГОН БЭХЖҮҮЛСЭН НЬ

Э.Золбоо

ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахмад zolboogoos@yahoo.com

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”¹ гэж заажээ. Үндсэн хуулийн заалтыг иш үндэс болгон Эрүүгийн хуульд “Хууль ёс, шударга ёс, энэрэнгүй ёс, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх”² зарчмуудыг хуульчилсан билээ.

Ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөний талаар судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлж энэ чиглэлийн тулгамдсан асуудлуудад шинжлэх ухааны үндэслэлтэй хариу өгөх явдал манай орны эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд судлаачдын нэн чухал зорилт болоод байна. Манай Ардчиллын цаашдын хувь заяа, түүний дотор хүний эрх, эрх чөлөөг улс орондоо бүрэн агуулгаар нь хэрэгжүүлж чадах эсэх нь эдгээр асуудлуудын онолын үндэслэлийг боловсруулж түүнийгээ практикт бүтээлчээр хэрэглэх явдлаас шалтгаалах нь тодорхой юм.

Түлхүүр үгс: Зарчим, энэрэнгүй ёс, ардчилал, хүний эрх, эрх чөлөө

¹Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992 он

²Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2002 он

Үндсэн хэсэг

1989 оны сүүлч, 1990 оны эхээр захиран тушаах дэглэмийг үндсээр нь халах гадаад, дотоод нөхцөл тохироо Монгол улсад нэгэнт бүрэлдсэний шууд үр дүн болж өрнөсөн ардчилсан хувьсгалын ололтыг 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ. Нийт ард түмнээс сонгогдсон 430 депутат 76 өдрийн турш оюун ухаанаа уралдуулан хэлэлцэж баталсан энэхүү ардчилсан Үндсэн хуулиар хүн төрөлхтний дэвшингүй хөгжлийн нийтлэг чиг хандлагыг иш үндэс болгон эх орондоо **хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилтыг**³ албан ёсоор тунхаглан зарласан төдийгүй НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдэд нийцүүлэн хүний эрх, эрх чөлөөг урьд өмнө байснаас ихээхэн өргөтгөж хуульчилсан юм. Энэ нь манай оронд хүний эрх, эрх чөлөө бодит зүйл болох үндэс суурийг тавьсан нэн ач холбогдолтой үйл явдал болов.

Аливаа эрх зүйн үндэс суурь нь Үндсэн хууль байдаг ба нэгдүгээрт Энэрэнгүй ёсны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд эрх зүйн зарчим болгон бэхжүүлснийг дараах байдлаар судаллаа. Тухайлбал,

1960 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуульд заасанчлан бидний замнаж ирсэн өмнөх нийгмийн зорилго нь “социализмыг төгөлдөр байгуулж цаашдаа коммунист нийгэм байгуулах”⁴ явдал байв. Ийм нийгэмд амьдарч буй хүмүүс тэрхүү зорилгод хүрэх хэрэгсэл нь болж байдаг бол ардчиллын нөхцөлд хүн өөрөө нийгмийн зорилго байдгаараа зарчмын ялгаатай. Өөрөөр хэлбэл ардчилсан нийгэмд хүн төрийн анхаарлын төвд байдаг зүй тогтолтой. Үүнтэй холбогдуулан Германы гэгээрүүлэгч, гүн ухаантан Иммануиль Кант “Ямар ч нөхцөлд хүнийг зорилго гэж үзэхээс бус түүнд хүрэх хэрэгсэл мэтээр хандаж болохгүй”⁵ гэж сургасан нь хүнийг нийгмийн төвд байлгах үзэл бүрэлдэн цаашид улам гүнзгийрч хөгжихөд ихээхэн түлхэц болсон чухал дэвшилттэй үзэл санаа байлаа. Хүнийг дээдлэх И.Кантын үзэл санааг гүн ухаантан Георг Вильгельм Фридрих Гегель өндрөөр үнэлж байсан бөгөөд тэрбээр “Хүнийг тойрон эргэлдүүлж байдаг цорын ганц татах хүч болох эрх чөлөө нь өлийж харах өчүүхэн ч зүйлгүй дээд оргил байх ёстой. Иймд өөрийг нь хэрэгсэхгүй эрх чөлөөг нь хүндэтгэхгүй ямар ч алдар хүндийг хүн хүлээн зөвшөөрөх учиргүй. Энэхүү

³Монгол улсын Үндсэн хууль, УБ, 1992, 3 дахь тал

⁴БНМАУ-ын Засаг захиргааны эрхтэй холбогдох хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл, №1, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, УБ, 1961, 6 дахь тал

⁵Иммануил Кант, Сочинения в шести томах., том-4, часть 1, Изд. Социально-экономической литературы “Мысль”, Москва, 1965, с-270

зарчмыг дэвшүүлэх нь урагшлах том алхам болно”⁶ гэж тэмдэглэсэн нь агуулга, ач холбогдлын хувьд өнөөдөр ч үнэ цэнэтэй хэвээр байна. Тухайлбал, тэрээр “эрх чөлөөг өлийж харах өчүүхэн ч зүйлгүй дээд оргил гэснээрээ хүний эрх чөлөөний халдашгүй байх шинжийг онцлон илэрхийлжээ.

Монголын ард түмэн хөгжлийнхөө чиг хандлагыг болгон сонгосон *өнөөгийн нийгэм маань хүмүүнлэг, энэрэнгүй, ардчилсан байх* тухай Үндсэн хуулийн удиртгал хэсэг дэх заалтыг агуулгын хувьд дээр дурдсан тэргүүний дэвшилтэт үзэл санаануудын үргэлжлэл, бодит биелэл гэж үзэж болох юм. Ийнхүү Монголчууд бид эх орондоо хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилтыг өмнөө тавин хэрэгжүүлж эхэлсэн нь дэлхий нийтийн ардчиллын жишиг хандлагад нийцсэн түүхэн чухал дэвшил билээ.

Зорилт дэвшүүлэх, түүнийг мөн чанараар нь бодит байдал дээр хэрэгжүүлэх хоёрын хооронд ямар нэг хийдэл гаргах эсэх нь төрийн бодлогод ардчиллын зарчмуудыг хэрхэн чанд баримтлахаас шалтгаалах болно. Тухайлбал, ардчилсан, хүмүүнлэг нийгэмд юуны өмнө Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө хүн бүр ямар ч саад тотгоргүйгээр эдлэх улс төр, эдийн засаг, эрх зүйн баталгааг төрөөс бүрдүүлж өгөх учиртай.

Улс орны түүхэн хөгжлийн зарим үе шатуудад дээрх баталгаа, түүний хэрэгжилт ямар байсныг өмнөх үеийн болон одоо үйлчилж байгаа Үндсэн хуулиудыг түүхчлэн харж, харьцуулан судлах нь онолын төдийгүй практикийн ач холбогдолтой бөгөөд аливаа нийгэмд ардчилал бодит зүйл болсныг харуулах гол шалгуур нь тухайн хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх нийгэм улс төрийн баталгаа байдаг. Энэ баталгаанд улс орны гол хууль шийдвэрлэх үүрэгтэй.

1924 онд БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуульд “Тус улсын харьяат ард түмэн угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэх ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино” /11-р зүйл/ гэж заасан атлаа “Ван, гүн, тайж нарын хэргэм зэрэг, аливаа хутагт хувилгаадын захирах тушаах ба ардын өмчид холбогдох эрхийг устгавал зохино” /13 дугаар зүйл/ гээд, аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүст бас тэднийг оруулсан байдаг.⁷ Мөн дээрх 11 дүгээр зүйлийн заалтад манай

⁶Георг Вильгельм Фридрих Гегель, Работы разных лет в двух томах, том-2, Изд. Социально-экономической литературы “Мысль”, Москва, 1970, с-144

⁷Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, УБ 1954, 205-206 дахь тал

улсын нутаг дэвсгэр дээр түр буюу тус улсын харьяат бус хүмүүс хамаарахгүй байгаа юм. Үүнээс харвал Үндсэн хуулиар нийт иргэдийг гарал, үүсэл, хэргэм зэргээр нь анги бүлгүүдэд хувааж нэг хэсгийнх нь эдэлбэл зохих эрхийг зөвхөн тэдний өмнөх албан тушаал, нийгмийн гарал, итгэл үнэмшлийг харгалзан эцнээгээр гэм буруутайд тооцож хассан нь уг Үндсэн хуулиар иргэдийн тэгш эрхийг тунхагласан чухал ололтыг нь үгүйсгэхэд хүргэхүйц алдаа байжээ. Тухайлбал энэ хуулиар сонгох сонгогдох эрхгүй хүмүүст мөлжлөгөөр амьдрагсад, дамын наймаачид, мөнгө хүүлэгчид, шүүхээр ял шийтгэгдэгсэд, ухаан солиорсон этгээдүүд багтаж байгаа бөгөөд зөвхөн, ван, гүн ба хутагт хувилгаад орон хийдэд суух санваартан лам байсных нь төлөө тэднийг гэмт хэрэгтэн, ял шийтгэгдэгсэдтэй адилтган иргэний эрхийг нь хассан явдлыг зарчмын үүднээс авч үзвэл ойлгомжгүй байгаа юм.

1932 онд манай орны зарим хэсэгт лам нарын бослого гарч олон хүний амь нас сүйрч цус урсахад хүргэсэн шалтгаан нь тэднийг энэ мэтээр ялгаварлан эрхийг нь хассантай нилээд хэмжээгээр холбоотой байсан.⁸ Гэсэн зарчим эрдэмтэд, судлаачдын үнэлэлт дүгнэлтийг бид дэмжиж байна.

1940 онд нэмэлт өөрчлөлт оруулж баталсан Үндсэн хуульд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэдийн биед халдаж үл болох явдлыг хангана.Шүүх таслах газрын тогтоолгүйгээр буюу хэн хүнийг баривчлан хорьж болно.”/86-р зүйл / “Ард иргэний орон сууцад халдаж үл болохыг ба өгөлцөх авалцах захидлын нууцыг хуулиар хамгаална” /87-р зүйл /”⁹ гэх зэргээр иргэдийн халдашгүй байх эрхийн талаар тусгаснаараа дэвшилттэй болсон байна. Мөн тус хуулийн 7-р бүлэгт “БНМАУ-д шүүх таслах хэргийг Улсын Дээд Шүүх таслах Газар Улаанбаатар хотын шүүн таслах газар”Аймгийн шүүх анги, нутгуудад шүүн таслах газруудаас гүйцэтгэнэ.” /49 дүгээр зүйл/, “Аливаа шүүх таслах газруудаас хэрэг таслахдаа хэрэв хуульд зориуд заасан хэрэг биш бол суух шүүн таслагчаас ардын төлөөлөгчдийг оролцуулан гүйцэтгэж байх” /50 дугаар зүйл/, “Шүүх таслах газар бүхэнд хэргийг таслахдаа илээр явуулах бөгөөд хэрэгтэн хүнд өмгөөлөх эрхийг эдлүүлнэ.” /55 дугаар зүйл/ ,”Шүүгч нь аливаа хэрэг таслахдаа бусдад хамаарагдахгүй, гагцхүү хуульд захирагдана.” /56 дугаар зүйл/¹⁰ гэж мөн шүүн таслах үйл ажиллагаа түүний ажиллах зарчим, бие даасан байдлын талаар анх удаа Үндсэн хуульд тусгасан нь энэ талаар

⁸С.Ганболд, Монголд 1932 онд гарсан зэвсэгт бослого, Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиолын хураангуй, УБ, 2000, 14 дэх тал

⁹БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл, УБ, 1972, 374 дэх тал

¹⁰БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл, УБ 1972, 368 дах тал, С.Жанцан, Шүүх засаглал, 2000, 67-69 дэх тал

нарийвчлан хуульчлагдах эрх зүйн эхний эх сурвалж болсон гэж үзэх үндэстэй. Гэвч хуульд сонгуулийг эрхийг нь хасах талаар түрүүчийн хуульд байсан хэм хэмжээ хадгалагдаад зогсоогүй, зарим талаар түүнд хамрагдах хүмүүсийн хүрээ өргөжсөн байна. Тухайлбал тус Үндсэн хуулийн 71 дүгээр зүйлд сонгуульд оролцох ба сонгогдох эрхгүй хүмүүст “ашиг олз хураах зорилгоор хөлсний хүчийг ашиглагчид ба мөнгө хүүлэгчид, урьдын хутагт хувилгаад, дээд лам нар, жинхэнэ засаг ба засаг бус хан, бэйл, бэйс, гүн түүнчлэн албат хамжлагатай байсан бөгөөд тэр хамжлагаа хатуу чангаар дарлан захирч байсан түшмэд, нөлөө бүхий бөө, удган, цагаан цэрэгт ба хувьсгалын эсэргүү бослогод идэвхтэйгээр оролцогсод, ухаан мэдрэл эвдрэгсэд хийгээд шүүх таслах газрын тогтоолоор сонгуулийн эрхээ хасагдаж шийтгүүлсэн хүмүүс”-ийг хамруулжээ.¹¹

1960 онд шинэчлэн баталсан Үндсэн хуульд хүний эрх мөн шүүхийн байгууллага, шүүн таслах ажиллагааны талаар өмнөх Үндсэн хуулиас ахицтай хуульчилж чадаагүй нь захиран тушаах дэглэмийн мөн чанартай холбоотой гэхээс өөрөөр тайлбарлах аргагүй юм. Энэ хуулийн талаар доктор (Sc.) Г.Совд “... хүний эрхийг өмнөх үетэй нь харьцуулахад ихээхэн дэвшилттэй заасан. Гэхдээ нэгдүгээрт хүний эрх, эрх чөлөө болон тус улсаас олон улсын харилцаанд хүлээх ёстой үүргийг хүндэтгэн үзээгүй, хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйл болдог ардчиллын гол зарчмууд бүрэн тусгагдаагүйгээр барахгүй хязгаарлалттай байв. Энэ нь зөвхөн нэг үзэл суртлыг сонголтгүй удирдлага болгож байсан захиргаадалтын тогтолцоонд хүлэгдэж байсантай холбоотой.”¹² гэсэн дүгнэлт хийсэн байна.

Монгол улсын шинэ Үндсэн хуульд /1992 оны/ тусгагдсан хүний эрх, эрх чөлөөний талаарх хэм хэмжээнүүдийн 2 дугаар зүйлд “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 10 дугаар зүйлд 10.1-т “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, 19 дүгээр зүйлд “1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна, 2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх,

¹¹БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл, УБ, 1972, 371 дэх тал

¹²Г.Совд, Хүний эрх хуульчилснаар аяндаа хэрэгждэггүй, “Шихихутуг” эрх зүйн шинжлэх ухааны онол арга зүйн сэтгүүл, 1999, №1, 23 дахь тал

итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө, 3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж тус тус хуульчилсан нь гэж хуульчилсан бидний судалж буй энэрэнгүй ёсны зарчимтай уялдаж байгаа юм.

Энэрэнгүй ёсны зарчмыг ийнхүү манай улсын шинэ Үндсэн хуульд өөрийнхөө байр суурийг эзлэн хуульчлагдсан байна. хуульчлах болсон шалтгааныг тодруулбал:

1. Монгол оронд ардчилал бодит зүйл болж хүний эрх, эрх чөлөөг хангах асуудал чухлаар тавигдах болсон нийгмийн шинэлэг нөхцөл байдал,
2. Олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлага,
3. Хүн төрөлхтний хэмжээнд явагдаж байгаа эрх зүйн глобалчлалын нийтлэг чиг хандлагыг бид үүнд хамааруулан үзэж байна.

Энэрэнгүй ёсны зарчмыг Монгол Улсын Эрүүгийн хуульд эрх зүйн зарчим болгон бэхжүүлснийг дараах байдлаар судаллаа. Тухайлбал,

Эрүүгийн эрх зүй гэдэг нь ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт ямар төрөл, хэмжээний ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэхийг тогтоож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон чөлөөлөх үндэслэл, нийтлэг зарчмуудыг тодорхойлох зорилгоор хууль тогтоох дээд байгууллагаас баталсан эрх зүйн хэм хэмжээнүүдийн цогц бүрдэл юм¹³ гэж тодорхойлсон байдаг.

Аливаа зарчим гэдэг нь практик үйл ажиллагаанд баримтлах шаардлагатай, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, практикаар шалгагдсан тэргүүний үзэл санаа юм. Тэгэхээр эрүүгийн эрх зүй нь хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргээ эрх зүйн нийтлэг ба тусгай зарчмуудыг чанд мөрдөх замаар амжилттай хэрэгжүүлэх боломжтой.

Монголын ард түмний төр ёсны үзэл, хууль цаазын сэтгэлгээ 2000 гаруй жилийн түүхтэй бөгөөд Монгол улсын хөгжил дэвшил, мандал буурлын үр дагавар мөн. Монголын нэгдсэн төрөөс өмнөх хууль цааз нь бүхэлдээ заншлын хэм хэмжээ агуулсан хэв хууль /МЭӨШ- МЭХШ зуунд / байсан ба хожим тэдгээр нь төрийн хууль цаазын эх үндэс болсон байна.

¹³С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн Эрх зүй /ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011., 30 дах тал

Манай улсын эрдэмтэн судлаачид¹⁴ аливаа хууль цаазын эрх зүйн зохицуулалтыг судлахдаа тухайн цаг үеийн нөхцөл байдал, төрийн дэглэм, хууль тогтоомжийн хөгжил, төрийн эрүүгийн бодлого зэрэг объектив ба субъектив хүчин зүйлүүдийг харгалзан үзэж ихэвчлэн монгол нутагт төр үүссэн цагаас хойш XIII зууны эхэн үе /Их Монгол улс оршин тогтнож байсан/, XIII зууны сүүлээс Монгол оронд Ардын хувьсгал ялсан 1921 он хүртэл үе, 1921 оноос-1990-ээд оны үе Ардчилал шинэчлэл өрнөсөн үе, 1990 оноос хойших үе гэсэн нийтлэг үечлэлээр авч үзсэн байна.¹⁵

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Энэрэнгүй ёсны зарчмын талаар Монгол Улсын хууль тогтоомжийн уламжлалыг судалсны үндсэн дээр дараах байдлаар түүхчлэн судлалаа.

1. 1921 оноос өмнөх хууль цаазын бичгүүдэд энэрэнгүй ёсны зарчмыг тусгасан байдлыг судалсан нь.
2. 1921 оноос-2002 он хүртэлх Эрүүгийн хууль тогтоомжид энэрэнгүй ёсны зарчмыг хуульчилсан байдал
3. 2015 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад энэрэнгүй ёсны зарчмыг хэрхэн хуульчилсан талаар харьцуулан судлахаар шийдлээ.

1921 оноос өмнөх хууль цаазын бичгүүдэд энэрэнгүй ёсны зарчмыг тусгасан байдлыг судалсан нь.

Монголын их хаан Чингисийн Их Засаг хэмээсэн яруу сайхан нэр, өвөрмөц гүн агуулгатай хууль цааз манай ард түмний соёл иргэншлийн бүхий л түүхийн туршид Монголчууд болон Монголыг судлаач, сонирхогчдын анхаарлыг үргэлж татаж ирсэн. Монгол үндэстнийг нэгтгэж, төвлөрсөн хүчирхэг улсыг үүсгэн, хэзээ ч гандан бууршгүй мөнхөд дурсагдах гавьяа байгуулсан. Эзэн богд Чингисийн их засгийн үүсэл, шинж, онцлог, бүтэц түүнийг монголын ба гадаадын олон эрдэмтэн, мэргэд

¹⁴Д.Лүндээжанцан, Ж.Болдбаатар-1. Монголын эртний төр эрх зүй (МЭӨ III-МЭ XIII), 2. Монголын дундад үеийн төр, эрх зүй (XIII-XX зууны эх), 3. Шинэ үеийн төр, эрх зүй (XX зууны 20-иод оноос 90 он), 4. Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй (1990-ээд он) гэж ангилсан байна. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 9 дэх тал
С.Нарангэрэл. Монгол оронд эрх зүй үүсэж, хөгжиж ирсэн он цагийн үечлэлийг: Нэгдүгээр үе (Монголын угсаатны улс үүсэн буй болсноос эхлэн Юань гүрний Нэвтэрхий хууль үйлчилж байсан үе), Хоёрдугаар үе (Ойрад-Монголын хууль үйлчилж эхэлснээс хойш 1921 он хүртэлх), Гуравдугаар үе (1924 оноос 1990) болгон ангилжээ. Монгол ба дэлхийн эрх зүйн тогтолцоо (Харьцуулсан эрх зүй) МУИС, ШУА. УБ., 2001.92 дахь тал
Монгол нутагт амьдарч байсан эртний улсуудын төр эрх зүйн талаарх судалгаа, шинжилгээний материал байдаг ч бидний судалгаанд хамаарах асуудлаар нэн ховор байсан тул эртний улс, овог аймгуудад энэ гэмт хэрэгтэй тэмцэх ирсэн уламжлалын судалгааг XIII зуугаас 1921 он хүртэлх үечлэлд нэгтгэн судалсан болно.

¹⁵С.Гантулга, Л.Бат-Очир, Б.Энхболд."Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг", УБ., 2012 он

ихээхэн судалсаар ирсэн. Энэ хуулиас хааныг сонгох, бишрэх, төрийг засах тэгшитгэх, улсын гадаад, дотоод бодлогыг явуулах, цэрэг, иргэнийг захирах, улс үндэс, газар нутаг, ус бэлчээр, ан амьтан, мал сүрэг, хэв ёсыг хамгаалах, аж ахуй хөтлөх, худалдаа арилжаа хийх, шашин суртал, заншлаа хүндэтгэх тухай заасан байдаг.

Чингис хаан зөвхөн хурдан хүлэг, хурдан зэвсэг, эр зоригоор улс гүрнийг нэгтгэн захирч, төрийг засан тохинуулж үл болно гэдгийг сайтар ухаж, засаг цааз, хэв ёс журам дүрмийг цэгцлэн тогтоож, иргэн бүхэнд даган мөрдүүлсэн байдаг. Чингис хааны хууль цаазыг зөрчсөн хэн боловч алагчлалгүй шийтгэгддэг байжээ.

Өөрөөр хэлбэл хууль цааз нь их эзэн хаанаас эхлээд иргэн бүрд тэгш үйлчилдэг байсан. Ийнхүү шударга ёсыг өөрөөсөө тэгш хэрэгжүүлсэн нь Чингис хааны Их монгол улс байгуулж чадсаны нэгэн нууц юм.

Их засаг хууль: тус хуулийн ерөнхий ангийн “Хаан төрийн тухай хууль” гэсэн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлд “Ноён хүн тухайн орон нутагтаа хааны нэрийн өмнөөс онцгой эрх дархыг эдэлдэг байсан ч эзэн хааныхаа өмнө тодорхой үүрэг хариуцлага хүлээж, жилд 2 удаа хаанд бараалхан сургаал зарлигийг нь сонсоод нутагтаа очоод хэрэгжүүлэх ажлаа өөрсдөө гардан хариуцах ёстой байв. Ингээгүй тохиолдолд ард нийтийг захирах эрх мэдэл нь шууд хүчингүй болдог байсан нь харагдаж байна. 7 дугаар зурвас: “Аравтын даргын тушаалыг биелүүлж чадаагүй хүмүүсийг даруй чөлөөлж, тэрхүү аравтын дотроос өөр нэгийг олж сонгох хэрэгтэй. Аливаа нэгэн зарлиг тушаалыг буулгахад заавал 3 хүн санаа нийлсэн байх хэрэгтэй. Тийм болбол сая биелүүлж болно. Гурван хүний дотор өөрийгөө оруулж тооцно. Өөрийн хэлснийг бусдын хэлсэнтэй, ялангуяа мэргэдийн яриатай адилтгаж үзэх хэрэгтэй. Эс бөгөөс зарлиг тушаалыг буулгаж үл болно. Өрх айл болон аравтын тогтолцоо нь монголын нийгмийн харилцааны үндэс, гол судас байсан бөгөөд төр улсын бүхий л хэрэг явдал чухамдаа аравтаас эхэлж байжээ. Удирдлагын шинжлэх ухааны үүднээс үзэхэд нэг хүн арваас илүүг удирдаж үл чадах нь бүрэн батлагдсан бөгөөд дэлхийн улс орнууд бүхий л түүхэндээ аравтын тогтолцооноос илүүтэй зөв зохион байгуулалтыг олж чадаагүй байна. Ингэхлээр төр нийгмийн болон хөдөлмөр зохион байгуулалтын дээд хэлбэр болох аравтын даргын ажил үүрэг хичнээн чухал болохыг энд заажээ. Нөгөө талаар аливаа удирдах хүний зоргоороо авирлах явдлыг хориглож асуудлыг хамтаараа шийддэг байхын чухлыг хуульчлан бататгасан байсан ба, тус хуулийн дөрөвдүгээр бүлэг “Ард иргэдийн хууль”-ийн 22 дугаар зүйлд “Хүн бүрийн ажил эрх тэгш, баян ядуу, эрхэм доорд гэж ялгаж үл болно. Төр улсын зүгээс ард

олноо баян, ядуу, эр эм, нас хүйс, үндэс угсаа, шашин шүтлэгээр нь үл ялгаварлан тэгш шударга хандах ёстой гэдгийг энд ийнхүү хуульчлан заасан байгаа агаад тэрээр XIII зуунд хүний эрхийг дээдэлсэн, тэгш ёсыг хамгаалсан энэрэнгүй сайхан ийм хуулийг зөвхөн Чингисийн монголчууд л гаргажээ. Энэ заалт нь олон үндэстэн ястантай асар том гүрний оршин тогтнолын нэг тулгуур болж байлаа. 23 дугаар зурвас: “Өтгөсийг хүндэлж, ядуусыг тэтгэх хэрэгтэй. Богд мэргэд ба бясалгагчдыг хүндэтгэвэл зохино.” Оюуныг дээдэлсэн заалт. Амьдралын их туршлагаар алдар гавьяатай өтгөс ахмад, авьяас чадвартай ном эрдмийн мэргэд нийгэмд гоц хэрэгтэйг цохон тэмдэглэжээ. 24 дүгээр зурвас: “Үл харгис, үнэнч шударга, цэгц журамтай, эрдэм гүн билэг хурц хүмүүсийг эрхбиш сайшаан хүндлэх хэрэгтэй бөгөөд зусар харгис болон элбэрэл журамгүй этгээдийг жигшин занаг тун. Сайныг дэмжиж саарыг жигших үзлийг нийгэмд хэвшүүлж, нийгмийн эрүүл саруул орчныг бүрдүүлэхэд чиглэсэн заалт болно” гэж тус тус хуульчилсан нь тухайн цаг үед мөрдөгдөж байсан хууль цаазын бичигт энэрэнгүй ёсны зарчим тусгайлан хуульчлагдаагүй боловч, тусгалаа олсон зүйл заалтууд харагдаж байна.

Юань гүрний нэвтэрхий хуульд: 1260 оны 5-р сард Хархорум хотноо Аригбөх их хуралдайг хуралдуулж өөрийгөө Их Монгол улсын хаан ширээнд өргөмжилсөн. Үүний дараахан буюу 1260 оны 6-р сард Хубилай хаан Кайпин хотноо хятад ноёд түшмэдээр дэмжүүлэн “Их хуралдай” гэгчийг хуралдуулж өөрийгөө “Их Монгол улсын зүй ёсны их хаан” хэмээн өргөмжилсөн байна.

1271 онд Хубилай улсынхаа нэрийг “**Юань**” хэмээн өөрчилсөн. Энэ нь “уг үндэс, язгуур угсаа” гэсэн хятад гаралтай үг юм. Хубилай Юань гүрний эзэн хаанд өргөмжлөгдсөнийхөө дараа юун түрүүн өөрийн эрх мэдэл, байр суурийг бэхжүүлэх арга хэмжээг авсан юм.

Мөн энэ хууль цаазын бичигт тусгайлан Энэрэнгүй ёсны зарчмыг хуульчилж өгөөгүй боловч насанд хүрээгүй хүн, төрийн эрх барих хүмүүст хүлээлгэх ял, хариуцлагад тусгалаа олсон зүйл заалтууд харагдаж байна.

Халх журам хуульд: *Халх журам хуулийг 1709 онд батлан 20-р зууны эхэн хүртэл даган мөрдөж байжээ. Халх журам нь монголчуудын үндэсний харилцааг зохицуулахад чиглэж байсан бол Монгол-Ойрадын хууль монголчуудын овог аймаг хоорондын харилцааг тохинуулах зорилготой байсан. Халх журамд төрийн, захиргааны, иргэний, гэр бүлийн, эрүүгийн эрх зүйн шинжтэй хэм хэмжээ тусгагджээ.*

Тус хуулийн Өртөөний тухай бүлгийн 11 дүгээр зүйлд “Яаралт элч улаачаа эс эрвээс өөр хүнд захиж яв. Яаралгүй элч эзэнд нь хэлж уна. Эзэн

нь үгүй бол сүрэг нэгт айлд нь хэлж уна. Айлын хүн эс зөвшөөрвөөс өөрийнхөө морийг өг. Хэрэв морь өгөхгүй бол хонь ав. Яаралгүй элч улаачаа эс хүлээвээс хонь ав. Яаралгүй элч хязаалангаас доош уна. Имаг /ямагт/ бүдхүүн морь болох аваас эзэн нь гараараа өг. Дээш унах ахул шүдлэн хонь ав. Улаач эзэнд нь эс хэлбэл шүдлэн хонь ав. Улаач улаагаа хулгй хийвээс хулгай хийсэн улхааныг /улааны морьдыг/ цөм аваад /хурааж аваад/ шүдлэн морь ав. Элчгүй улаач бусадтай хуйвалдаж өөр газар нутагт шилжүүлээд баригдвал хүн бүрээс шүдлэн морь ав. Эзэнгүй адуунаас хулгй хийж барьсан улааг /морьдыг/ яаралгүй элч бүү уна. Хэрэв унаваас талчилсан /хуйвалдсан/ лугаа адил. Гаднаас ирсэн ноёдын элчид өөрийн хошуудын улаач нь ноёд, дархадаас бүү барьж өг. Барьж өгвөөс шүдлэн морь ав. Энэ гурван хошууны элч мэдэж барьж унаваас шүдлэн үхэр ав. Элч хажуу айлчлах мэт явах бол улааг нь буцааж өгөх. Эс өгвөөс сонгодог хонь авах. Элч гэртээ нартай байтал хонох ахул маргааш нь өөрийн мориор явж бай” гэх мэт заалтуудад энэрэнгүй ёсны зарчим тусгалаа олсон байсан ба харин тусгайлан хуульчлагдаагүй байна.

Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг: Монгол төр, эрх зүйн түүхэнд холбогдох нэгэн чухал сурвалж нь Олноо Өргөгдсөн Богд хаант Монгол Улсын үеийн буюу 1913-1918 оны хооронд үйлчилж байсан “Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм” юм. Энэхүү эх сурвалж нь “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийг үйлчлэх хүртэлх нийгмийн харилцааг зохицуулж байжээ. “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийг зохиолгохоор 1915 онд Богд хааны зарлигаар комисс байгуулж¹⁶, манж чин улсын үеийн “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг” болон бусад хуулийг нягтлан монгол хэлээр орчуулж таван дэвтэрт нэгтгэсэн байна.

¹⁶Шинээр хууль цааз зохиох газрыг байгуулахаар хэлэлцсэн нь. Нэгэн зүйл. Хууль зүйлийн бичгээс чухал хэрэглэвээс зохихуйг нь ялган салгаж залруулан тогтосугай хэмээн айлтгаад зарлиг ёсоор болгосон хэргийн нугайбарыг үзэж хянаваас урьдаар хууль зохиох хүрэнхэн байгуулж олон газар орноос бичиг хэрэгт боловсронгуй түшмэдийг ирүүлэн, тухай дор олон яамнаас сайд түшмэлийг томилж Шүүх яамнаа хавсарган захиуулж хамт хуралдан хэлэлцэж тогтоовоос ямар хэмээн хэлэлцсэн явдлыг дээд хуралд толилуулан тогтоолгохыг эрсүгэй хэмээн үүнд хорин зургааны Дээд хуралд үзэж Доод хурлын энэ мэт төлөвлөн цохсон нь зүйтэй тул эл хээргт олон яамны тэргүүн сайдууд дахин зөвлөж чадах сайд түшмэдийг сонгон томион гаргаж гүйцэтгүүлье хэмээвэй. /1915.05.07./. Монгол Улс, УТА, хм-А-1, д-1, хн-1, х.27-28, хуулга. Монгол Улсын дээд, доод хурал. Баримт бичгийн эмтхгэл. I дэвтэр /1914-1916/, Эмхтгэсэн Ж.гэрэлбадрах., Ү.Дэлгэрмаа, Э.Жавзандулам, УБ., 2003 он. 144 дэх тал.

1918 онд уг хуулийг зохиож, хэлэлцэн батлах үе үндсэндээ дуусаж хэвлэх ажиллагаа эхэлжээ.³

Уг цаазын бичигт Эрүүгийн хариуцлагад татах насны хязгаарыг тодорхой заагаагүй боловч, “89 настай байхдаа цаазаар авах ялаар шийтгүүлсэн, мөн 10 нас хүрээгүй үедээ хийсэн хэрэг нь илэрсэн тохиолдолд ямар гэмт хэрэг үйлдсэнийг үл харгалзан насанд хүрээгүй гэж үзэж мөн хуульд зааснаар ялыг хөнгөлнө” гэх мэт олон зүйл заалтуудад бидний судалж буй энэрэнгүй ёсны зарчим хуульчлагдаагүй боловч тусгалаа олж байсныг харж болохоор байна.

1921 оноос-2002 он хүртэлх Эрүүгийн хууль тогтоомжид энэрэнгүй ёсны зарчмыг хуульчилсан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд: “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”¹⁷ гэж хуульчлан, тунхагласан байдаг.

Үндсэн хуулийн энэ тулгуур заалтыг иш үндэс болгон 1993 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Эрүүгийн хууль нь шударга ёс, энэрэнгүй ёс, хуулийг чанд сахих, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, хариуцлага гарцаагүй байх зарчимд үндэслэнэ”¹⁸ гэж анх удаа хуульчилсан чухал ач холбогдолтой болсон юм.

Эрүүгийн эрх зүйн зарчим гэдэг нь гэмт явдалтай тэмцлийн зүй тогтлыг илэрхийлсэн, Эрүүгийн хуульд заасан, хууль тогтоох, сахиулах, хэрэглэх байгууллага, албан тушаалтан, иргэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутайг нотлох, ял оногдуулах үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих үзэл санааны цогц бүрдэл юм.¹⁹

Эрүүгийн эрх зүйн зарчим гэдэг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд, иргэд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа заавал мөрдөж байх ёстой нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, амьдралаар шалгагдсан үзэл санааны цогц бүрдэл юм.²⁰ Иймд Эрүүгийн эрх зүй судлаач, эрдэмтэд Эрүүгийн эрх зүйн зарчмыг тодорхойлж иржээ.

Эх бичгийн судалгаа. УБ., 2004 он. 10 дахь тал Эх бичгийн судалгаа. УБ., 2004 он. 10 дахь тал

¹⁷Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000. 2 дахь тал

¹⁸Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 1993 он

¹⁹С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий ба тусгай анги/. УБ., 2011 о., 30 дахь тал

²⁰Проф Г.Совд. “Эрүүгийн эрхийн үндсэн зарчмуудыг эрүүгийн эрхийн утга агуулгыг тодорхойлж, түүний үйлчилгээнд удирдамж болдог гол үзэл санааны нийлбэр” /БНМАУ-

Аливаа түүхэн эрин үе, аливаа нийгэм улс төрийн байгуулал нь нийгмийнхээ хөгжлийн бодит байдлыг тодорхой хэмжээгээр илэрхийлсэн эрх зүйн зарчимтай байжээ. Тухайлбал, Феодалын эрхзүйд тэгш бус байдал хэвшмэл байдаг бол өнөөгийн ардчилсан нийгэмд хуулийн өмнө эрх тэгш байх нь эрх зүйн зарчмын нэг болж байна.²¹

Эрүүгийн эрх зүйн зарчмын агуулга зорилт нь төгс төгөлдөр эрх зүйн тухай үзэл санааны илэрхийлэл болсон эрх зүй, төрийн онолын нийтлэг зарчмуудаас шууд урган гардаг. Эрх зүйн бүх зарчим анхандаа эрх зүйн ухамсраас үүдэлтэй гэдэг утгаараа эрх зүйн ухамсар хууль бүтээх ажиллагааны үндэс юм.

Эрх зүйн нийтлэг зарчмууд нь эрх зүйн хэм хэмжээнд тусгагдаж байж хэм хэмжээний агуулгатай болдог учир эрх зүйн ухамсрын зарчимтай нийцсэн байх шаардлагагүй. Зарчмуудын агуулга болон тэдгээрийн ангилалт, эрх зүйн онол болон эрүүгийн эрх зүйд өөр өөр байх ёстой нь нэгэнт тодорхой юм.

Эрх зүйн зарчмуудыг эрх зүйн бүх тогтолцоонд хамаарч эрх зүйн салбаруудад өөрийн өвөрмөц агуулгаар илэрч байдаг **нийтлэг зарчим**, тодорхой салбар эрх зүйн зохицуулалтын онцлог шинжүүдийг илэрхийлдэг **тусгай зарчим** гэж хоёр үндсэн төрөлд ангилан авч үздэг.

2002 онд батлагдсан шинэ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3-9 дүгээр зүйлд: Хууль ёс сахих, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга ёс, энэрэнгүй ёсыг чанд мөрдөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зэрэг нийтлэг болон тусгай зарчмуудыг хуульчилсан нь²² Эрүүгийн хуулийн зорилтыг хангах, Эрүүгийн хуулийг зөв, нэг мөр хэрэглэх, гэмт хэргийг зүйлчлэх, ялыг тохируулж оногдуулахад чухал ач холбогдолтой болсон.

Эрүүгийн хуулийн зарчмуудад олон улсын хамтын ажиллагааны /интернационализм/ болон ардчилсан зарчмуудыг хууль тогтоогч хамруулаагүй байна.

Интернационализмын зарчим нь тоталитар тогтолцооны үед социалист үзэл суртлын үзэл санаанд тулгуурлаж байсан бөгөөд ЗСБНХУ

ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973.10 дах тал/ гэсэн бол Академич С.Нарангэрэл “Эрүүгийн эрхийн зарчмуудыг хууль тогтоох болон хэрэглэх үйл ажиллагаанд заавал хэрэглэгдэх гол суурь болсон эрх зүйн үзэл баримтлал” гэж тодорхойлсон байна. /Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ.,1999, 15 дахь тал /

²¹С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ.,1999, 2 дахь тал

²²Монгол Улсын Эрүүгийн хууль ба Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002 он

болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орнуудтай тогтоосон харилцааг Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр дэмжих агуулга, зорилготой байсан нь хуучин Эрүүгийн хуульд тусгалаа олж байсан.

Тухайлбал, 1986 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 139 дүгээр зүйлд “БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа социалист бусад орны улс, хоршоолол, олон нийтийн өмчийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол уг хуулийн тусгай ангийн 3-р бүлгийн аль тохирох зүйлд зааснаар ял шийтгэнэ”²³ гэж заасан нь тэр үеийн пролетарийн интернационализмын зарчмын илрэл болж байсныг гэрчилжээ.

Капиталист орнуудын өмч хөрөнгийг манай улсын нутаг дэвсгэр дээр ашиглан шамшигдуулбал амины өмчийн эсрэг хэргээр хариуцлага хүлээлгэхээр байсан.

Мөн түүнчлэн, энэ байдал 1960 оны Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлд, хөдөлмөрчдийн засаг төр бүхий бусад улсын эсрэг онц аюултай гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр тогтоосон заалт, мөн хуулийн 50 дугаар зүйлд дайныг сурталчлагчдад Эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай заалт нь орон бүхний хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл, энх тайвныг хамгаалах, бэхжүүлэх зорилтоор батлагдаж байжээ.

1921 он: Энэ үед бие даасан хууль байгаагүй. Энэ үеийн эрүүгийн эрх зүйн эх сурвалж болох түүхэн баримт бичиг гэвэл а/ Ардын засгийн газрын хурлаас гаргасан хуульчилсан акт, б/ шүүх яамнаас гаргасан актууд /тушаасан бичгүүд/, в/ улс төрд онц ноцтой хэргийг таслуулахаар засгийн газраас байгуулсан комиссын тогтоол зэрэг хэлбэрээр гарч байв. Тухайлбал: Ардын засгийн газрын 1921 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 7 дугаар хурлын тогтоолын арван нэг дэх зүйлд заасны дагуу хуучин хуульд байсан алах цөлөх дөнгө дөнгөлөх пүнлүү хасах золио авах ялын хорих торгох ял болгон өөрчилсөн. 1921 оны 8-р сарын 3-ны өдрийн засгийн газрын хурлаар эх орноосоо урвах гэмх хэргээс бусад хэрэгт алах ялыг 10 жил хорих, алгуурлан алах ялыг 7 жил хорих, улсын хязгаарт цөлөх ялыг 5 жил хорих, аймаг алгасаж цөлөх ялыг 3 жил хорих, зэргэлдээ аймагт цөлөх ялыг 1 жил хорих ял болгон өөрчилж хоригдлын ял эдлэх хугацаанд хөдөлмөр хийлгэх болжээ. Мөн пүнлүү хасах золио авах ялыг торгох ял болгож ял шийтгэл ногдуулахдаа тайж аард гэж ялгаварлан үзэхийг зогсоожээ.

1926 он: Шүүх цаазын бичиг. Ардын хувьсгалын жилүүдэд дагаж мөрдөж байсан анхны эрүүгийн хууль бөгөөд ЗХУ-ын эрүүгийн хуулийн үлгэр дуурайлаар зохиогдсон. Шүүх цаазын бичиг нь ерөнхий ангийг 7 бүлэг 40 зүйлтэйгээр тусгай ангийг 24 бүлэг 187 зүйлтэйгээр батлагдсан.

²³БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989. 179 дэх тал

Шүүх цаазын бичгийг анх боловсруулж баталсан явдал нь шинэ төрийн хууль тогтоох үйл ажиллагаанд гарсан том амжилт эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг анх удаа нэгтгэн тогтоосон эрүүгийн эрх зүйн онол хөгжих суурь тавигдсан чухал үйл явдал байв.

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хүмүүжүүлэх, 15-17 насны хүүхдийг ялтнаас тусад нь хорих бага насны хүүхдийг эцэг эхэд нь даалган өгч хүмүүжүүлэх эмэгтэй хүмүүсийг тусад нь хорих жирэмсэн бол чөлөөл олгох зэрэг байдлаар энэрэнгүй ёсны чухал заалтууд одоо хүртэл хэвээр байна.

1929 он: шүүх цаазын бичиг 1926 оны шүүх цаазын бичгийн дараагийн хууль нь юм. 1929 оны хууль нь шинэ бие даасан хууль биш бөгөөд 1926 оны хуулийн шинэчилсэн найруулга юм. 1926 оны шүүх цаазын бичгээс өөрчлөгдсөн гол зүйл нь гэвэл ерөнхий ангийн 5-р бүлэг /ял хорогдуулах ба хөнгөрүүлэх/6-р бүлэг буюу /ял хүндрүүлэх/-ийг нэгтгэж “аливаа гэмт явдал үйлдэгчдийг засан сайжруулахын тулд хэрэглэх зүйлүүдийг хэрхэн баримтлан гүйцэтгэх тухай” гэсэн нэг бүлэг болгосон.

Хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан хүмүүс мөн хөхүүл хүүхэдтэй жирэмсэн эмэгтэй цаазаар авах ял хэрэглэж болохгүй гэмт хэрэг үйлдсэн 14 хүртэлх насны хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй тус хуулийн 6 дугаар зүйлд “Буудан алах ялыг үл хэлэлцэх этгээдүүд” гэсэнд “Анх гэмт явдал өдүүлсэн үест 18 насанд хүрээгүй хүмүүс, хөхүүл хүүхэдтэй буюу жирэмсэн бүсгүйчүүд нар болмой”, 7 дугаар зүйлд “Эм хүнийг бусад хэрэгтэн ялтнаас тусгай хорихоос гадна хэрвээ бие жирэмсэн бол төрөхийн урьд хожид бүгд 6 сарын чөлөө олговоос зохимой” гэх зэрэг нэлээд хэдэн нэмэлт өөрчлөлт орсон нь энэрэнгүй ёсны зарчмын үзэл санаа байжээ.

1934 он: Шүүх цаазын бичиг. Энэ хууль нь эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэгдсэн. Энэ хуулийн онцлог гэвэл анх эрүүгийн хуулийн зорилтыг тодорхойлж гэмт хэргийн тухай тодорхойлолтыг өгсөн байна. Ерөнхий ангийн 6 бүлэг 41 зүйлтэй, тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр баталсан. Энэ удаад хуулийг буцаан хэрэглэх үндэслэл, журмыг тодорхойлж өгсөн. Мөн хуулийн 17 дугаар зүйлд “Буудан алах ял бол улсыг хамгаалах онц арга хэмжээ мөн учир, туйлын хүнд гэмт хэрэгт хэрэглэх бөгөөд басхүү шүүх таслах газраас ялтан этгээдэд мөнхүү гэмт хэргээн дахин үйлдэхийг цээрлүүлэх өөр аргагүй гэж үзсэн буюу ард түмний дайсан этгээдийг айлган сүрдүүлэх онц чухал учир тохиолдолдсон тухай дор хэрэглэнэ”, “Уул гэмт хэрэг үйлдсэн цаг үест насанд хүрээгүй байсан ба жирэмсэн буюу хөхүүл нялхас бүхий

эмэгтэйчүүдэд буудан алах ял унагааж үл болно” гэсэн нь мөн л энэрэнгүй ёсны зарчим хуульчлагдаагүй ч үзэл баримтлалд тусгалаа олсон байсныг харж болохоор байна.

1942 он: Эрүүгийн хууль. Монгол улсад Социализмыг үнэс суурийг тавих үед дагаж мөрдөж байсан эрүүгийн эрх зүйн эх сурвалж мөн. Цаг үеэ дагаад нилээд өөрчлөлт орсон. Ерөнхий анги нь 6 бүлэг 54 зүйлтэй, тусгай анги нь 10 бүлэг 165 зүйлтэй батлагдсан. Энэ хууль нь 1934 оны эрүүгийн хуультай харьцуулахад нэлээд боловсронгуй болсон боловч эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг олгож байснаараа дутагдалтай байсан. Хууль ёсны зарчим хараахан бэхжээгүй байсан ч тус хуулийн Хоёрдугаар бүлгийн “Эрүүгийн хуулийн журамлан дагаж хэрэглэх хэмжээ хязгаар” хэсгийн 5.1-т “Хэрэв уул хэрэг үйлдэх цагт гэмт хэрэг тооцогдсон боловч энэхүү хуульд гэмт хэрэгт үл тооцогдох буюу эсвэл ялыг хөнгөтгөх учир байгаа бол энэхүү хуулийн буцаан хэрэглэх хүчинтэй болно” мөн 10-т “Гэмт хэрэг үйлдэх үед үргэлжийн буюу түр ухаан солиурах өвчинтэй байсан буюу өөр өвчний эрхээр чухам үйлдсэнээ эс ухамсарласан ба мөн түүнчлэн гэмт хэрэг үйлдэхээ ухаан бүрэн байсан боловч таслан шийтгэх үед ухаан баларсан өвчин тохиолдвол ял шийтгэж үл болно” гэж хуульчлагдсан нь үзэл баримтлалд тусгалаа олсон байсныг харж болохоор байна.

1961 он: Эрүүгийн хууль. Энэ хууль нь олон жилийн турш дагаж мөрдсөн бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх Эрүүгийн эрх зүйн үндсийг бүрдүүлж байсан байна. Өмнөх эрүүгийн хуулиас ялгагдах онцлог нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх явдлыг хориглосон явдал нь хүний эрхийг дээдлэх хууль ёсны чухал алхам болжээ. Хуулийг ерөнхий ангийн 5 бүлэг 44 зүйл, тусгай ангийн 11 бүлэг 221 зүйлтэйгээр баталсан. Тус хуулийн 6 дугаар зүйлд “Насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэх эрүүгийн хариуцлага” хэсэгт “Б.Арван найман нас хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг нь нийгэмд учруулсан хор аюулаар их биш, түүнд заавал эрүүгийн шийтгэл хэрэглэж хүмүүжүүлэх явдалгүй гэж шүүх үзвэл хуульд заасан албадан хүмүүжүүлэх өөр арга хэмжээ авч болно”, мөн 7 дугаар зүйлд “Ухаан санаа нт эрүүл бус этгээдэд хариуцлага хүлээлгэж болохгүй байдал” хэсэгт “Нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, өөрөөр хэлбэл сэтгэл мэдрэл нь архаг өвчтэй буюу түр гэмтсэний улмаас эсхүл өөр бусад өвчний уршгаар өөрийн үйлдлийг хариуцан тайлбарлаж , ухаан санаагаар жолоодож чадахгүй байсан хүнийг гэмт хэрэгтэн гэж үзэх бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй” гэсэн нь мөн энэрэнгүй ёсны зарчим хэрэгжиж байсныг илтгэж байна.

1986 он: Эрүүгийн хууль гэмт хэргийн анхны ангилалтыг хийж гэмт хэргийн тухай тодорхойлолтыг өгч, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал ял тэнсэх институтыг боловсронгуй болгосон. 2-р зүйлд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг заахын хамт “Хуульд нийцүүлэн гаргасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолгүйгээр хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож буюу эрүүгийн ял оногдуулж болохгүй” гэсэн чухал зарчмыг хуульчилжээ. Тус улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн БНМАУлсын иргэн, харъяалалгүй этгээд БНМАУлсын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдан буюу шүүхэд шилжсэн бол тэдэнд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Эдгээр хүмүүс үйлдсэн гэмт хэрэгтээ хилийн дагуу хөнгөрүүлж буюу гэм буруутай этгээдийг ял эдлэхээс бүр мөсөн чөлөөлж болно. Хэрэв БНМАУлсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүй тооцож болно” гэсэн нь мөн энэрэнгүй ёсны зарчим хэрэгжиж байсныг харуулж байна.

Хуулийг ерөнхий ангийн 5 бүлэг 59 зүйл, тусгай ангийн 13 бүлэг 301 зүйлтэйгээр баталсан байна. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилгээ”, Үндсэн хуулийн хавсралт хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын хууль ба олон улсын гэрээний хүний эрхийн талаархи заалт зөрчигдвөл уул гэрээний заалтыг баримтална” гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн этгээр заалтууд нь олон улс дамнан үйлдэгдсэн, тэдгээрийн ашиг сонирхолд хохирол учруулдаг хар тамхи, зэвсэг хууль бусаар наймаалах, хүн, онгоц барьцаалах, хүн худалдаалах, бохир мөнгө угаах зэрэг олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж эхэлсэн байна.

Монгол Улс 1991 онд олон улсын цагдаагийн байгууллага болох Интерполд гишүүнээр элсэн, сүүлийн үед гэмт хэрэгтэй тэмцэх тухай хэд хэдэн олон улсын конвенцид нэгдэж соёрхон баталж, улмаар үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдөж байгаа юм. Ийнхүү улс төрийн адил болон ойролцоо тогтолцоо бүхий зарим улсуудыг сонгох байдлаар хамтран ажиллахын оронд нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн үндсэн дээр дэлхийн бүх дэвшилтэт орнуудтай гэмт хэрэгтэй хамтын тэмцэл явуулах болсон нь чухал ач холбогдолтой болж байна.

Ардчилсан ёсны зарчим Эрүүгийн эрх зүйд онцгойрох ач холбогдолгүй бөгөөд эрх зүйт төртэй улсад бүх хууль тогтоомж ардчилсан байдаг. Тийм учраас энэ зарчим Эрүүгийн хуульд хуульчлагдаагүй юм. Өмнө нь Эрүүгийн эрх зүйд ардчилсан зарчмын агуулга нь гол төлөв гэмт хэрэгтэй тэмцэхэд хөдөлмөрийн хамт олон, иргэдийн оролцоогоор илэрч байсан.

Хуучин тогтолцооны Эрүүгийн хуульд анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг олон нийтийн шүүхэд, насанд хүрээгүй хүмүүсийг хянах комисст шилжүүлэх тухай хэм хэмжээ үйлчилж байсан үед ардчилсан ёсны зарчим бодит байдлаар хэрэгжиж байсан.

1990 оноос иргэдийн оролцооны эрх зүйн үндсийг хүчингүй болгосон учир хууль тогтоогч энэ зарчмыг хуульчлаагүй гэж үзэж байна²⁴ гэж судлаач Б.Мөнхдорж бүтээлдээ дурдсан байна. Тиймээс гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэд, байгууллагын оролцоо, чухал учраас “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх тухай” хуулийн 9,10 дугаар зүйлд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гэмт хэрэгтэй тэмцэхэд гүйцэтгэх үүргийг хуульчилсан боловч бүрэн хэрэгжиж чадахгүй байна.

2002 он: Эрүүгийн хууль: Эрүүгийн хуулийн ерөнхий ангид эрүүгийн эрх зүйн зарчмуудыг улам боловсронгуй болгон хуульчлахын зэрэгцээ үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн эрүүгийн хуулиар тодорхойлно. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.

Иргэний үзэл бодол итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй гэм буруугүйгээр энэ хуульд заасан хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй гэсэн орчин үеийн эрүүгийн эрх зүйн үзэл баримтлалуудыг шууд зааж өгсөн явдал нь онцлог болсон.

Эрүүгийн хууль тогтоомжийн хууль ёс ардчилсан болон энэрэнгүй ёсны зарчмуудыг улам төгөлдөржүүлэх, эрүүгийн хуульд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тулгуур зарчмуудыг шинээр хуульчлан тогтоох урьд байсан зарчмуудын агуулгыг улам боловсронгуй болгох онцлог байсан байна.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн “МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОРИЛТ, ЗАРЧИМ” гэсэн 1 дүгээр бүлгийн 7 дугаар зүйлд Энэрэнгүй ёсны зарчмыг дараах байдлаар хуульчилсан байна.

Үүнд: Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр,

²⁴Б.Мөнхдож “Эрүүгийн хуулийн зарчим” судалгааны ажлын 20 дахь тал

алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй²⁵ гэж хуульчлан мөрдөж эхэлсэн юм.

2015 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад энэрэнгүй ёсны зарчмыг хэрхэн хуульчилсан талаар харьцуулан судалъя:

2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх Монгол Улсын шинэ Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцлийг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, Монгол Улс олон улсын гэрээ, конвенцид шинээр нэгдэн орсон, соёрхон баталсан, түүнчлэн өөр бусад хууль шинээр батлагдаж, зарим хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор хийгдэж ирсэн боловч өнөөгийн нийгмийн харилцааны хөгжил, эрэлт хэрэгцээтэй холбон авч үзвэл Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг бүрэн дүүрэн хамгаалж чадаагүй, даяарчлагдаж буй эрин үед олон улсын нийтийн эрх зүйн хөгжлөөс хоцрох хандлагатай байна гэж үзэн Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол улсын Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн найруулан баталсан юм.

Шударга ёсыг хамгаалах тогтолцооны үндсийг бүрдүүлэх үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, ХЗҮХ, МУИС-ийн ХЗС, ХСИС зэрэг судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдаас Эрүүгийн хуулийн эерэг болон сөрөг үр нөлөө, хэрэгжилтийн талаар хийсэн 10 гаруй судалгаа, хуулийн төсөлд²⁶ дурдсан Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зарчим, ерөнхий анги, тусгай ангийг бүхэлд нь шинэчлэх талаарх байр суурь, санал шүүмжлэл, зөвлөмжийг харгалзан үзэж, ардчилсан нийгмийн харилцаанд тохирсон, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага урган гарч байна гэж хууль тогтоогчид үздэг.

Энэ хуулийн үзэл баримтлалд Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хийх өөрчлөлтийн талаар дурьдахдаа 2-т “Ерөнхий ангид нэрлэж, томьёолсон зарчмуудын агуулгыг шинээр томьёолж “Хууль ёсны зарчим”,

²⁵Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002 7.1 дах зүйл

²⁶Т.Мэндсайхан ахлагчтай судалгааны багаас хийсэн “Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал”, ХЗҮХ-гээс 2004, 2009 онуудад хийсэн “Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал” гэсэн суурь судалгаа, ХЗДХЯ-ны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгээс боловсруулсан зарим баримт, бичигт дурдсан схем, шүүмж, санал, дүгнэлт, зөвлөмжүүд, Академич С.Нарангэрэлийн боловсруулсан “Эрүүгийн төрөлжсөн хуулийн төсөл”

“Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим”, “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим”, “Шударга ёсны зарчим”, “Энэрэнгүй ёсны зарчим”, “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим”, “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим” гэсэн 7 зарчмын агуулгыг өөрчилж боловсруулна. Ингэснээр шүүх хуульд заасан зарчмыг баримталж хэрэг шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзсэн байна.²⁷

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан 2002 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн захиалга, шаардлагаар уг хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгох” зорилтыг дэвшүүлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томъёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд Эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл чиглэгдэж байна²⁸ гэж тус хуулийн үзэл баримтлалд тусгагдсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлс болох хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас бодитой хамгаалахын тулд хувь хүнээс гадна хуулийн этгээдийг гэмт хэрэг, зөрчлийн субъектэд тооцож, хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалтыг оруулснаар олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ.

Мөн тус хуулийн үзэл баримтлалын 8-д “онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал, урьд ял шийтгүүлсэн, гэмт хэрэг давтан үйлдсэн гэж хүндрүүлэн үзэхээр нэрлэн заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж, Тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй байхаар хуулийн төсөлд тусгана. Эрүүгийн хуулийн нийт 49 зүйлд

²⁷ХЗҮХ-гээс 2012 онд Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн судалгаанаас үзэхэд шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ зарчмыг дурдаж, үндэслэл болгон хэрэглэдэггүй, зарим зүйл хэсэгт зарчим гажуудахад хүргэсэн заалт байгааг онцлон дурдсан байдаг.

²⁸Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлалд 2015 он.

гэмт хэргийг давтан үйлдсэн, 13 зүйлд урьд ял шийтгүүлсэн бол хүндрүүлж үзэхээр заажээ. Энэ нь нэг хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн “Non double jeopardy” зарчмыг гажуудуулахад хүргэж, аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг өөрчлөн хуулийн төслийн Ерөнхий ангид “ял хүндрүүлэх нөхцөл байдал” гэсэн хэсэгт тусгана”. 9-д “Ял, шийтгэл нь гарцаагүй байх ёстой боловч давтан гэмт явдлын шалтгаан байх ёсгүй байдлыг харгалзан сонгон хэрэглэх боломжтой хянан харгалзах арга хэмжээ болох эмнэлгийн чанартай, хянан харгалзах, эрх хасах, хязгаарлах, хүүхдэд хүлээлгэх хариуцлагын төрлийг шинээр хуулийн төсөлд тусгана. Ингэснээр хянан харгалзах арга хэмжээ нь сонгон оногдуулах боломжтой байх ба хорих ялыг багасгаж, үр нөлөөтэй, хүний хувийн байдалд тохирсон байх шинжийг харгалзан үзэх боломжтой болно. Уламжилж ирсэн “эрүүгийн хариуцлага” гэсэн ойлголтыг “ял шийтгэл” хэмээн тодорхойлж, энэ дотроо ял, хянан харгалзах арга хэмжээ гэсэн 2 хэсгээс бүрдэхээр тусгасан. Ял үр нөлөөтэй байх зорилгыг хангах үүднээс ял эдэлж дууссаны дараа хянан харгалзах арга хэмжээг хэрэгжих байдлаар хуулийн төсөлд тусгана. Мөн тус хуулийн үзэл баримтлалын тусгай ангид оруулах өөрчлөлтийн 13-т “Хүүхдэд хүлээлгэх ялын төрлийг хуулийн төсөлд тусгай бүлгээр зохицуулах бөгөөд “насанд хүрээгүй этгээд” гэсэн нэршлээс зайлсхийж, “хүүхэд” гэж гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүнийг ойлгохоор томъёолсон. Ял шийтгэл хүлээлгэх насны хязгаарыг 14 наснаас байхаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд бусад орны Гэмт хэргийн тухай хуульд заасан ял шийтгэл оногдуулах насны хязгаарын шалгуурыг харгалзан үзсэн. Энэ нь 14 наснаас дээш гэмт хэрэг үйлдсэн хүүхэд бүрт ял оногдуулах зорилгогүй бөгөөд хүүхдийн хүмүүжил нас бие, сэтгэхүйн онцлогт тохирсон ял шийтгэл оногдуулах тусгай бүлэгтэй харилцан уялдаатай байх талаар хуулийн төсөлд тусгана. Эрүүгийн хуульд зааснаас үзэхэд 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн гэж тодорхой заасан боловч шүүхийн практикт ял оногдуулах үед насанд хүрсэн гэдгээр эрх зүйн байдлыг дордуулан хэрэглэж, насанд хүрсэн хүний нэгэн адил ял оногдуулдаг байдлыг анхаарч, энэ нь олон улсын наад захын стандарт жишиг, дүрмүүдтэй нийцэхгүй байгаа тул цаашид зөвхөн гэмт хэрэг үйлдэх үедээ 21 нас хүрсэн хүний зарим онцлогийг харгалзан хүүхдэд оногдуулах журмыг хэрэглэж болох талаар хуулийн төсөлд тусгана” гэсэн нь тус тус энэрэнгүй ёсны зарчмын агуулгатай хууль бий болсныг харж болохоор байна.

Харин эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдан батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад бидний судалж буй “Энэрэнгүй ёсны зарчим” хуульчлагдаагүй боловч хуулийн агуулгад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ, давтан гэмт хэрэг гэж байхгүй болсон, мөн өсвөр насны хүнд ял оногдуулах, ял хөнгөрүүлэх нөхцөл байдал гэх мэт бараг хуулийг тэр чигт нь энэрэнгүй ёсны зарчмын агуулга харагдаж байна.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийг Ардын хувьсгал ялж, анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах ажлыг эхлүүлсэн 1921 оноос хойш тооцож үзвэл, 1926, 1929, 1934 оны “Шүүх цаазын бичиг”, 1942, 1961, 1986, 2002 оны “Эрүүгийн хууль”-иуд нь залгамж чанартай, тухайн цаг үеийн улс төр, үзэл суртлыг агуулсан шинжтэй байсан хэдий ч түүхэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж иржээ.

2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд энэрэнгүй ёсны зарчим нь анх хуульчлагдаж, хэрэгжүүлж ирсэн байна. Гэтэл 13 жилийн дараа буюу 2015 оны Эрүүгийн хуулиас хассан боловч энэрэнгүй ёсны зарчмын агуулга бүхий зүйл заалтууд нилээд тусгалаа олж, хуульчлагдсан байдаг.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль., 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль., 2002 он
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль., 2002 он
4. Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/., 2015 он
5. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл., 2008 он
6. Хүний эрх //Олон улсын гэрээ.хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ.,1998 он
7. ХЭҮК-ийн 2008 оны тайлан
8. Монгол улсын Олон улсын гэрээ. I боть. УБ., 2004 он
9. Уголовный кодекс РФ.М., 1996
10. БНХАУ-ын Эрүүгийн хууль
11. Япон Улсын Эрүүгийн хууль
12. Э. Авирмэд, Д.Дашцэрэн, Г.Совд “Монгол хууль”., УБ.,1997 он